

**МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД  
ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 10 дугаар  
сарын 07 -ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн Л.Эрдэнэчимэг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай болон холбогдох бусад хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон харилцааны хамрах хүрээг өргөжүүлж, худалдааны чөлөөт байдлыг хангах зорилгод нийцүүлэн мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтнаас хүнд дамжин халдварладаг өвчний эрсдлийг бууруулах, мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын нутаг дэвсгэрт мал, амьтны өвчингүй эрүүл, тайван байдлыг баталгаажуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор хууль санаачлагч энэхүү хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун, О.Баасанхүү, Ж.Батзандан, С.Батболд нар төсөл санаачлагч болон ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, хариулт авав.

Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун энэ хуулийн төсөл нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн харилцааг зохицуулж байгаа тул шинээр хууль гаргалгүйгээр нэмэлт, өөрчлөлт оруулах замаар сайжруулах;

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан монгол уламжлалт нүүдлийн мал аж ахуйдаа тохирсон, дэлхийн жишигт нийцсэн малын эрүүл мэндийн системийг бий болгох;

Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү төслийн 21.1.3-т заасан мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд ариун цэврийн магадлан шинжилгээ хийх гэсэн нь хяналтын асуудал байна. Иймээс төсөлтэй холбогдуулан хяналттай холбоотой бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах;

Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр малын эрүүл мэндийн асуудал нь дэлхийн нийтийн шаардлагаас хоцрогдсон, энэ нь нэг малчны асуудал биш төрийн бодлогоор зохицуулах асуудал тул өмнө нь хэрэгжүүлж байсан бодлогыг эргэж харах;

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хууль хэрэгжих үндэс нь санхүү төсөвтэй холбоотой асуудал, малын халдварт өвчинтэй тэмцэх, вакцинжуулах

зардал улсын төсвөөс гардаг байсан зохицуулалтыг хэвээр үлдээх зэрэг саналыг тус тус гаргасан болно.


Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мал, амьтны эрүүл мэндийн тухай болон холбогдох бусад хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



С.БАТБОЛД